



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 14/179

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр хот хоорондын хатуу хучилттай замын урд байрлалтай 180,2га (1802265м<sup>2</sup>), 158,09 (1580939м<sup>2</sup>) газрыг Малын тэжээл бэлтгэх, малын тэжээлийн үр үйлдвэрлэх зориулалтаар эзэмшигч “Мал аж ахуй Эрдэм шинжилгээний хүрээлэн” (1700472)-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны А/77 дугаар захирамж болон уг захирамжийн дагуу гаргасан газар эзэмших эрхийн 000298043, 000298041 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмших гэрээний эрхийг дуусгавар болгож, газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг Газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ОДГЭРЭЛ



401300257